



BE ALWAYS CONNECTED WITH YOUR LAWYER

# LEGAL NEWSLETTER

2024 October №50

AKP Law Firm

Бид энэ оны 10 дугаар сард батлагдсан онцлох УИХ-ын болон Засгийн Газрын тогтоол болон энэ сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн "Тусгайлсан журмаар хэрэг хянах шийдвэрлэх ажиллагаа"-г танилцуулж байна.

Энэ сард шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон хууль байхгүй болно.

## I. УИХ-ЫН ТОГТООЛ:

2024 оны 10 дугаар сард нийт 2 УИХ-ын тогтоол батлагдсан байна.

### 1.1. ТУСГАЙ ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТУХАЙ

"Тусгай хяналтын дэд хороо" гэдэг нь УИХ-ын дэргэд ажилладаг, тодорхой асуудалд тусгайлан хяналт тавьж, шалгалт явуулдаг дэд хороо юм. Энэхүү дэд хороо нь улсын нууц, үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлуудыг хянан шалгах үүрэгтэй байдаг. Уг хороог шинэ бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

### 1.2. ЗАРИМ БАЙНГЫН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

- УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны гишүүн болон
- УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүний бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан байна.

## II. ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

2024 оны 10 дугаар сард нийт 12 Засгийн газрын тогтоол батлагдсан ба тэдгээрээс дараах тогтоолуудыг онцолж байна.

### 2.1. ГАЗРЫГ УЛСЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНД АВАХ ТУХАЙ (132 дугаар тогтоол)

Газрын тухай хуулийн 16.1.13, 18.1.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.2.1-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас уг тогтоолыг баталсан байна.

**Засгийн газрын байгууллагуудын цогцолборыг барих зориулалтаар Төв аймгийн Сэргэлэн сумын 1000 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авч, давхцаж буй газар ашиглалттай холбоотой шилжүүлэлтийг хуульд нийцүүлэн зохицуулахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдад үүрэг болгожээ**

### 2.2. ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ (Засгийн газрын 247 дугаар тогтоолд)

Дээр дурдсан Засгийн газрын байгууллагуудын нэгдсэн цогцолборын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, бүтээн байгуулалтын ажил, зохион байгуулалттай холбоотой мэдээллийг "Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт"-ын "В/ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР", "И/БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЛБАР" хэсэгт нэмэлтээр оруулж **төрийн маш нууц зэрэглэлийн нууцад хамааруулсан байна.**

### 2.3. ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ (худалдан авах ажиллагааг зохицуулах)

Мөн л дээр дурсан төрийн нууцад хамааруулахаар болсон мэдээлэлтэй холбогдон "Төрийн нууцад хамаарах худалдан авах ажилладаг зохицуулах журам"-ыг баталсан байна.

*"Төрийн нууцад хамаарах худалдан авах Ажиллагааг зохицуулах журам" холбоос:*



## III. ТУСГАЙЛСАН ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА:

2024 оны 1 сарын 17-ны өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлт болох "Тусгайлсан журмаар хэрэг

хянан шийдвэрлэх ажиллагаа” нь энэ оны 10-р сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн.

### 3.1. ТУСГАЙЛСАН ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ХЭРЭГ

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс (13.200.000₮) дээшгүй үнийн дүнтэй мөнгөн хөрөнгө гаргуулах дараах маргааныг шүүгч дангаар тусгайлсан журмаар шийдвэрлэнэ.

- Бүх төрлийн гэрээний дагуу мөнгөн хөрөнгө гаргуулах
- Дундын өмчийн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдсон зардал гаргуулах
- Хөдөлмөрийн гэрээний дагуу цалин хөлс гаргуулах
- Бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд гэм хор учруулсны улмаас мөнгөн хөрөнгө гаргуулах

Дараах нэхэмжлэлийг Үнийн дүнгээс үл хамааран шүүх тусгайлсан журмаар хянан шийдвэрлэнэ.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх зорилгоор эд хөрөнгө, эрхийг битүүмжлэх, хураах, үнэлгээ тогтоох, албадан дуудлага худалдаа явуулах ажиллагаатай холбоотой гомдол
- Үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах нэхэмжлэл
- Ажилд эгүүлэн тогтоосон хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг үндэслэн ажилгүй байсан хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх олговор гаргуулах нэхэмжлэл

Харин гэр бүл, өв залгамжлалын холбогдолтой бүх төрлийн хэрэгт тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх журам үйлчлэхгүй.

### 3.2. ТУСГАЙЛСАН ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ОНЦЛОГ

Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг нэг шүүх хуралдаанаар, бичмэл болон цахим баримтад тулгуурлан шийдвэрлэнэ.

Хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа нь шүүхийн ачааллыг бууруулж, хэргийг хурдан, үр дүнтэй шийдвэрлэх боломжийг бүрдүүлж, тухайн хэргийн онцлогт тохирсон шударга шийдвэр гаргахад чиглэсэн онцлог зохицуулалт юм.

### 3.3. ТУСГАЙЛСАН ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ХУГАЦАА

№	Ажиллагаа	Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх хугацаа	Энгийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх хугацаа
1	Хэрэг үүсгэх	5 хоног	Нийслэл 7 хоног Орон нутаг 14 хоног
2	Нэхэмжлэлийн шаардлага нэмэгдүүлэх	Нэг удаа, хэрэг үүсгэснээс хойш 5 хоногийн дотор	Шүүх хурал товлогдохоос өмнө
3	Нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөн, эсхүл татгалзсан үндэслэл түүнийг нотлох баримтаа шүүхэд ирүүлэх	Нэхэмжлэлийг гардан авснаас хойш 5 хүртэл хоногийн дотор	Нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор
4	Сөрөг нэхэмжлэл гаргах	Нэхэмжлэлийг гардаж авснаас хойш 7 хоногийн дотор	шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхээс өмнө
5	Хэрэг хянан шийдвэрлэх хугацаа	45 хоног	60 хоног
6	Хэрэг хянан шийдвэрлэх хугацаа (дахин хэлэлцүүлэхээр буцаасан)	15 хоног	30 хоног
7	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа сунгах	Нэг удаа 14 хүртэл хоног	Нэг удаа 30 хоног
8	Давж заалдах журмаар гомдол гаргах хугацаа	7 хоног	14 хоног

#### ALISON & KATE PARTNERS

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Pearl tower А блок 902 тоот  
 Web: [www.akp.mn](http://www.akp.mn)  
 E-mail: [contact@akp.mn](mailto:contact@akp.mn)  
 Tel: 7704-1414, 9511-3680